APU COMPANY
Absolute. Pure. Unique.

## АПУ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 25/03
Улаанбаатар хот

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйл, АПУ ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3-д заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь**:

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал”' гэх)-ыг 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 14:00 цагт цахим хэлбэрээр хуралдуулсугай.

2. Энэхүү тогтоолыг баталсан тухай мэдэгдлийг 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн дотор Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсүгэй.

3. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Монголын хөрөнгийн биржийн болон Компанийн цахим хуудсаар нийтэд зарлаж, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр дамжуулан 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдөр мэдээлсүгэй (давталтыг 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр явуулсугай).

4. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөр тогтоосугай.

5. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдөр үнэт цаасны брокер дилерийн компаниудад хүргүүлсүгэй. Санал авах хуудсаар санал авах сүүлчийн хугацааг 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 18:00 цагт байхаар тогтоосугай.

6. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

   Хурал зохион байгуулах комиссын дарга:
   - Б.Сарантунгалаг (ТУЗ-ийн нарийн бичгийн дарга)

   Хурал зохион байгуулах комиссын гишүүд:
   - Б.Мягмар (ТУЗ-ийн ажлын алба)
   - Б.Эрдэнэтуяа (ТУЗ-ийн ажлын алба)
   - Э.Солонго (Хууль, ТУЗ-ийн ажлын алба)
   - Д.Баясгалан (Мэдээллийн технологийн алба)
   - Б.Мөнхтэнгэр (Байгууллагын харилцааны алба)

7. Хурлаар хэлэлцэх асуудлуудыг нэгдүгээр хавсралтаар батлсугай.

8. Хурлын саналын хуудсын загварыг хоёрдугаар хавсралтаар батлсугай.

9. Хурлын даргаар Компанийн Гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэгийг томилсугай.

10. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Тооллогын комиссын дарга:

С.Дөлгөөн (БиДиСек ҮЦК ХК, Хөрөнгө оруулалтын албаны захирал)

Тооллогын комиссын гишүүн:

Г.Энхжин (БиДиСек ҮЦК ХК, Харилцагчийн албаны шинжээч)

11. Компанийн бүртгэгдсэн хувьцаа эзэмшигчдэд Хурал хуралдуулах тухай зар мэдээг нийтэд мэдээлсэн өдрөөс эхлэн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой, Компанийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6-д дурдсан баримт бичигтэй цахимаар танилцах боломжийг бүрдүүлэхийг Гүйцэтгэх захирал, Хурал зохион байгуулах комисст даалгасугай.

12. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хурлыг зарлан хуралдуулж, хурлын зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.

| № | Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн |
|---|---|---|---|---|
| 1 | П.Батсайхан | | | |
| 2 | Б.Батбаяр | | | |
| 3 | Кеннет Чу | | | |
| 4 | Сэн И-Ин | | | |
| 5 | Б.Гантиг | | | |
| 6 | Б.Гомбо-Эрдэнэ | | | |
| 7 | Ё.Гэрэлчулуун | | | |
| 8 | О.Одбаяр | | | |
| 9 | Ж.Үнэнбат | | | |

АПУ ХК–ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн
25/06 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт

**2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР ХУРАЛДАХ
АПУ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ**

1. АПУ ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллыг хэлэлцэж батлах.

АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн
25/13 тоот тогтоолын хоёрдугаар хавсралт

# 2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР ХУРАЛДАХ АПУ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: ......................................................................
Регистрийн дугаар: ..................................................................................
Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн
Эзэмшиж буй хувьцааны тоо: ........................................................................

Энэхүү санал авах хуудсаар 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 14:00 цагт цахимаар хуралдах хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

| № | Хурлаас гарах шийдвэр | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн | Татгалзсан бол санал |
|---|---|---|---|---|---|
| 1 | АПУ ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах | | | | |
| 2 | АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллыг батлах | | | | |

Санал өгсөн хувьцаа эзэмшигч.............................................................(гарын үсэг)

Брокер (ҮЦК-аар дамжуулж санал өгсөн бол).......................................(гарын үсэг, тэмдэг)

Санал өгсөн огноо: 2025 оны ........ сар ........ өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон:

Тооллогын комиссын дарга:...............................................................(С.Дөлгөөн)

Хүчингүйд тооцсон бол шалтгаан: ..........................................................................
..............................................................................................................................

**Санал авах хуудсыг ашиглах санамж:**

1. Хувьцаа эзэмшигч нь хурлын бүртгэлийн өдөр буюу 2025 оны 04-р сарын 04-ний өдрөөр эзэмшиж буй хувьцааны тоогоор санал өгнө.
2. Цахим хуралд оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчид өөрийн харилцдаг үнэт цаасны компани эсвэл хурлын тооллогын комиссоор ажиллаж буй БиДиСек ҮЦК ХК (Залуучуудын өргөн чөлөө 27/1, 8-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот) дээр очиж хурлын материалтай танилцаад энэхүү санал авах хуудсаар 2025 оны 04 сарын 23-ны өдрийн 18:00 цаг хүртэл урьдчилан санал өгөх боломжтой.
3. Саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт √ тэмдгийг бичнэ үү.
4. Тэмдэглэгээ хийгээгүй, засварласан, балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
5. Хувьцаа эзэмшигч өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулсан байна.

*Translation from Mongolian*

**APU JSC**
**BOARD OF DIRECTORS RESOLUTION**

Date: 14 March 2025 No. 25/..03

Ulaanbaatar

**CALLING ANNUAL GENERAL MEETING OF SHAREHOLDERS**

Pursuant to Article 60 of the Company law of Mongolia and clause 7.3 of the Charter of APU JSC (hereinafter "the Company"), it is hereby RESOLVED to:

1. Convene an Annual General Meeting of Shareholders (hereinafter "the Meeting") of the Company virtually on 24 April 2025 at 2:00 PM;
2. Give notice to the Mongolian Stock Exchange and the Financial Regulatory Commission about the adoption of this resolution on or before 17 March 2025;
3. Publish a meeting notice on both websites of the Mongolian Stock Exchange and the Company and announce through the mass media including daily newspapers or nationwide broadcasters (radio or television) on 19 March 2025 /to re-announce on 3 April 2025/;
4. Fix a registration date to make a name list of shareholders entitled to attend the Meeting to be 4 April 2025;
5. Deliver the meeting agenda, draft resolution, voting ballot and other relevant documents to brokerage and dealing companies on 24 March 2025 and set the ballot voting deadline as 23 April 2025 at 6:00 PM;
6. Appoint the following persons to a Meeting Organizing Committee:

   Head of the Meeting Organizing Committee:
   B.Sarantungalag (Board Secretary)

   Members of the Meeting Organizing Committee:
   B.Myagmar (Board Secretariat)
   B.Erdenetuya (Board Secretariat)
   E.Solongo (Legal & Board Secretariat)
   D.Bayasgalan (Information Technology) and
   B.Munkhtenger (Corporate Affairs)
7. Approve the Meeting agenda as per annex 1 hereto;
8. Approve the ballot template as per annex 2 hereto;
9. Appoint Ts.Erdenebileg, CEO of APU JSC, as the Meeting chairperson;
10. Appoint the following persons to a Tabulation Committee:

    Head of the Tabulation Committee:
    S.Dulguun (Director, Investment Department, BDSec UTsK JSC)

    Member of the Tabulation Committee:
    G.Enkhjin (Analyst, Client Department, BDSec UTsK JSC)

11. Direct the CEO and the Meeting Organizing Committee to provide shareholders with the opportunity to review the documents pertaining to the Meeting agenda items as specified in clause 65.6 of the Company law from the date of public announcement of the meeting notice; and

12. Direct the Meeting Organizing Committee to convene the Meeting, disseminate the Meeting notice and implement this resolution in accordance with applicable laws and regulations.

| № | Directors | For | Against | Abstain |
|---|---|---|---|---|
| 1 | P.Batsaikhan | | | |
| 2 | B.Batbayar | | | |
| 3 | Kenneth Choo | | | |
| 4 | Seng Yi-Ying | | | |
| 5 | B.Gantig | | | |
| 6 | B.Gombo-Erdene | | | |
| 7 | Yo.Gerelchuluun | | | |
| 8 | O.Odbayar | | | |
| 9 | J.Unenbat | | | |

УЛААНБААТАР ХОТ
"АПУ" ХК-ийн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
ТТС8896 ☆ 2702673

*Translation from Mongolian*

Annex 1 to Resolution No. 25/03 of
the Board of Directors of APU JSC,
dated 14 March 2025

**AGENDA ITEMS OF APU JSC ANNUAL GENERAL MEETING**
**TO BE HELD ON 24 APRIL 2025**

1. To approve the conclusion drawn by the Board of Directors on the 2024 operational and financial report of APU JSC; and
2. To approve the Board of Directors’ remuneration.

*Translation from Mongolian*

Annex 2 to Resolution No. 25/03 of
the Board of Directors of APU JSC,
dated 14 March 2025

**BALLOT PAPER FOR APU JSC ANNUAL GENERAL MEETING TO BE HELD ON 24 APRIL 2025**

Full name of the shareholder: ....................................................
Registration number: ..................................................................
Type of shares: ordinary
Number of shares: .......................................................................

This ballot will be used for voting at the annual general meeting of shareholders of APU JSC to be held virtually on 24 April 2025 commencing at 2:00 PM.

| № | Proposed resolutions to be adopted by the meeting | For | Against | Abstain | Suggestion if voted against |
|---|---|---|---|---|---|
| 1 | To approve the Board of Directors conclusion on the 2024 operational and financial report of APU JSC | | | | |
| 2 | To approve the Board of Directors' remuneration | | | | |

Filled in by: Shareholder ................................................................ (signature)

Broker /if voted through broker company/........................................ (signature and stamp)

Date of voting: ...... (dd) ...... (mm) 2025
The ballot has been counted as valid by:
Head of the Tabulation Commission ................................................ (S.Dulguun)

If deemed invalid, the reason for such decision: ..........................................................................
........................................................................................................................................
........................................................................................................................................

**Instructions:**

1. You will vote according to the number of shares held as of the meeting registration date (4 April 2025).
2. If you are unable to attend the virtual meeting, you can vote by filling in the ballot either at your brokerage company or BDSec UTsK JSC (the tabulation committee) before 23 April 2025 at 6:00 PM.
3. To fill in the ballot paper, please vote by marking (√) in the box that you chose.
4. Ballots will be deemed invalid if unmarked, corrected, or erased.
5. If you intend to appoint someone to represent yourself, please provide your representative with a notarized power of attorney.